



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 13/05

Эрдэнэт

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Орон нутагт чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"- ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгаж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Ээлжит XIII хуралдааны 130 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албыг бэхжүүлэх, чадавхжуулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.4-т “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.4.1-т “Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ” гэж тус тус заажээ. Мөн Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 8.2.3-т “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, сургалт, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллана” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Жил тутамд өсч буй хүн амын тоотой уялдуулан төрийн үйлчилгээг иргэдэд адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх, иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн шинэ арга барилыг нэвтрүүлэх, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай хүртээмжтэй болгохын тулд шинэ техник, технологи, тоног төхөөрөмж ашиглах, орон нутагтаа сургалтын баазтай болж, дотоод болоод гадаадын мэргэшсэн багш, мэргэжилтнүүдээр ажлын байран дээрх сургалтыг тасралтгүй явуулан ур чадвартай ажилтан, албан хаагчдыг бэлтгэх, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах шаардлага зүй ёсоор гарч байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-д төрийн бүтээмжийг сайжруулах зорилгын хүрээнд аймгийн хэмжээнд төрийн албанд ажиллаж буй албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн төлөвшлийг сайжруулах, гадаад харилцааг нээлттэй түвшинд хүргэх, нийгмийн асуудлыг дэмжих, шинэ технологи, арга барилыг орон нутагт нэвтрүүлэх, мэргэшсэн, хүний нөөцийн тогтвортой байдлыг төрийн албанд хангах үүднээс энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын Үндсэн хуулийн 46- дугаар зүйлийн 46.3, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.1, 60.1.2, 60.1.3, 60.1.16 дахь хэсэг, Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын 3.3.2.6, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын

2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны хөтөлбөрийн 5.4, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.4.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого, Орхон аймгийн ИТХ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам зэрэг бодлогын бичиг баримтуудыг үндэс болгов.

ХОЁР.ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2021 оны жилийн эцсийн байдлаар Орхон аймагт төрийн 96 байгууллага үүнээс төрийн захиргааны 27, төрийн тусгай чиг үүргийн 5, төрийн үйлчилгээний 64 байгууллагад нийт 4319 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн байгууллагын байршлаар нь авч үзвэл Баян-Өндөр суманд 90, Жаргалант суманд 6 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудад төрийн улс төрийн албан тушаалтан 35, төрийн захиргааны албан тушаалтан 430, төрийн үйлчилгээний 3777 албан хаагчид төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Төрийн байгууллагуудад ажиллагсдын 1029 буюу 23.8 хувь нь эрэгтэй, 3290 буюу 76,2 хувь нь эмэгтэй албан хаагч байна. Насны бүлгээр авч үзвэл 20-25 нас 256 буюу 5.9 хувь, 26-35 нас 1223 буюу 28.3 хувь, 36-45 нас 1314 буюу 30.4 хувь, 46-55 нас 1306 буюу 30.2 хувь, 56-60 нас 192 буюу 4.4 хувь, 61-аас дээш нас 28 буюу 0.06 хувийг эзэлж байна. Дийлэнх буюу 58.7 хувийг 26-45 насныхан эзэлж байгаа бөгөөд мэргэжлийн ур чадварыг ахиулах, нийгмийн асуудалд анхаарах, 56-60, 60 ба түүнээс дээш насны албан хаагч 4.5 хувийг эзэлж байгаа нь хүний нөөцийн төлөвлөлтөд тухайн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэж ажиллах шаардлагатайг харуулж байна.

Төрийн 47 байгууллагын 1328 албан хаагчдаас авсан судалгааны дүнгээс харахад боловсролын хувьд доктор 8, магистр 266, бакалавр 1043 албан хаагч ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын төрийн албанд ажилласан байдлаар авч үзэхэд 1-5 жил ажилласан 360 буюу 27.1 хувь, 6-10 жил ажилласан 304 буюу 22.9 хувь, 11-15 жил ажилласан 194 буюу 14.6 хувь, 16-20 жил ажилласан 189 буюу 14.2 хувь, 20-иос дээш жил ажилласан 281 буюу 21.2 хувь нь ажиллаж байна.

Харин тухайн байгууллагад 1-5 жил ажиллаж байгаа 532 буюу 40.1 хувь, 6-10 жил ажиллаж байгаа 304 буюу 22.9 хувь, 11-15 жил ажиллаж байгаа 179 буюу 13.5 хувь, 16-20 жил ажиллаж байгаа 148 буюу 11.2 хувь, 20-оос дээш жил ажиллаж байгаа 165 буюу 12.5 хувь нь байна.

Хөтөлбөр боловсруулахтай холбогдуулан төрийн байгууллагуудын албан хаагчдаас авсан санал асуулгын судалгааг нэгтгэхэд амьдрах нөхцөл, нийгмийн баталгааны талаар асуулгад 1231 хамрагдсанаас 565 буюу 45.8 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууцанд, 118 буюу 9.5 хувь нь бусдын эзэмшлийн орон сууцанд, 334 буюу 27.1 хувь нь өөрийн эзэмшлийн хашаа байшинд, 90 буюу 7.3 хувь нь бусдын эзэмшлийн хашаа байшинд, 92 буюу 7.4 хувь нь түрээсийн орон сууцанд, 32 буюу 2.5 хувь нь түрээсийн хашаа байшинд амьдарч байна.

Зээлтэй эсэх судалгаанд 95 хувь нь тийм, 5 хувь нь үгүй гэж хариулсан ба ямар төрлийн зээлтэй эсэх асуултад 1388 хүн хамрагдсанаас орон сууцны зээлтэй

308 буюу 22.1 хувь, хашаа байшингийн зээлтэй 75 буюу 5.4 хувь, 868 буюу 62.5 хувь, автомашины зээлтэй 153 буюу 11.0 хувь, сургалтын зээлтэй 52 буюу 3.7 хувь байна. Зээлийн дүн хэмжээний судалгаанд 1.0-10.0 сая хүртэлх төгрөгийн зээлтэй 403 буюу 40.0 хувь, 11.0-20.0 хүртэлх сая төгрөгийн зээлтэй 286 буюу 29 хувь, 21.0-30.0 сая төгрөгийн зээлтэй 87 буюу 9.0 хувь, 31.0-40.0 сая төгрөгийн зээлтэй 52 буюу 5.0 хувь, 40-ээс дээш сая төгрөгийн зээлтэй 167 буюу 17.0 хувь байна.

Та өөрийн мэргэшил болон ур чадвараа дээшлүүлэх зорилгоор төрөөс зохион байгуулж байгаа аливаа богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж чадаж байгаа эсэх асуултад тийм гэж 387 буюу 34.2 хувь, заримдаа гэж 520 буюу 45.9 хувь, үгүй гэж 220 буюу 19.4 хувь, бөглөөгүй 4 хүн байна.

Таны ажиллах нөхцөл хангагдаж чадаж байгаа юу гэсэн асуултад 534 буюу 40.5 хувь нь сэтгэл ханамжтай, 594 буюу 45.0 хувь нь сэтгэл дундуур, 89 буюу 6.7 хувь нь сэтгэл ханамжгүй, 101 буюу 7.6 хувь нь хариулаагүй байна. Та төрийн албан хаагчтай холбоотой аливаа нийгмийн баталгаанд хамрагдаж чадаж байгаа юу гэсэн асуултад тийм гэсэн асуултад 604 буюу 46.0 хувь, үгүй гэсэн асуултад 604 буюу 46.0 хувь, бөглөөгүй 101 буюу 8 хувь байна. Танай байгууллага сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр, төлөвлөгөөтэй юу гэсэн асуултад тийм гэж 654 буюу 49.6 хувь үгүй гэж 105 буюу 7.9 хувь, мэдэхгүй гэж 545 буюу 41.3 хувь, 14 буюу 1.0 хувь нь хариулаагүй байна.

ГУРАВ .ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, сургалт, баталгааг холбогдох хууль, журмаар зохицуулсан бөгөөд төрийн байгууллага бүр сургалт болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч дотоод нөөц бололцоо, төсөв, санхүүгээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь төрийн албан хаагчдын ажилдаа хандах хандлага, идэвх, санаачилга буурах, ажлаас гарах шалтгаан болж улмаар төрийн албаны тогтвортой, мэргэшсэн байх зарчимд нөлөөлж байна.

Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийн бодлогод тусгаснаар төрийн бүх шатны байгууллагууд зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай, мэргэшсэн төрийн албан хаагчдын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Төрийн бүх шатны байгууллага нь үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтайгаар явуулах гол хөшүүрэг нь мэдлэг, мэдээлэл, ур чадвартай байх бөгөөд гадаад, дотоод орчны байнгын өөрчлөлт нь төрийн албан хаагчдаас мэдлэг чадвараа цаг үргэлжид дээшлүүлж байхыг шаардаж байна.

Төрийн албан хаагчийн сурах болон ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг нь бодит тооцоо, судалгаанд үндэслэн тэгш, хүртээмжтэй, ил тод шийдвэрлэж байж, албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай, идэвх санаачилгатай ажиллуулах нөхцөл байдал бүрдэнэ гэж үзэж байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн баталгааг ханган цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг тухай бүрд нь олгохын зэрэгцээ ажиллагсдын ажиллах нөхцөл болон орон сууцны нөхцөлийг сайжруулах, түрээсээр болон бусад хэлбэрээр орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх, бие бялдрыг эрүүлжүүлэх,

чийрэгжүүлэх арга хэмжээ авах зэргээр тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ

4.1 Хөтөлбөрт Орхон аймгийн төрийн албан хаагчид хамрагдана..

4.1.1.Улс төрийн албан хаагч (Багийн Засаг даргаас бусад улс төрийн албан хаагч хамрагдахгүй)

4.1.2.Төрийн захиргааны албан хаагч

4.1.3.Төрийн тусгай албан хаагч

4.1.4.Төрийн үйлчилгээний албан хаагч

4.2.Төрийн албан хаагч нь орон нутгаас хэрэгжүүлж байгаа салбарын чиглэлийн хөтөлбөрт хамрагдахаар бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

5.1.Хөтөлбөрийн зорилго

5.1.1.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, сурах болон нийгмийн баталгаа хангах зорилтуудыг хэрэгжүүлсний үндсэн дээр тогтвор суурьшилтай, мэргэшсэн, үр бүтээлтэй, ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлсэн, чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, бэхжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

5.2.Хөтөлбөрийн зорилт

5.2.1.Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулан ногоон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх

5.2.2.Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган, тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх

5.2.3.Өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭМЖЭЭ

6.1.Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:

6.1.1.Ажилтан бүрийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан байгаль орчинд ээлтэй ажлын байр /албан өрөө/-аар хангахад дэмжлэг үзүүлэх

6.1.2.Албан хаагчдын албан тасалгааг шаардлага хангасан тавилга, тоног төхөөрөмж, компьютер, бусад техник хэрэгсэл, харилцаа, холбоо мэдээллийн хэрэгсэл зэргээр хангах, дэвшилтэт техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, дулаан, агааржуулалт, цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн байлгах

6.1.3.Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, гал, ус, цахилгаан хангамжийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

6.1.4.Төрийн үйлчилгээний албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл болон холбогдох хууль, тогтоомжид заасан бусад зүйлээр хангахад дэмжлэг үзүүлэх

6.1.5. Албан ажлын хэрэгцээ шаардлагаар зайлшгүй тохиолдолд албаны унаа, техник хэрэгсэл ашиглах боломж, бололцоог бүрдүүлж өгөх

6.1.6. Төрийн байгууллагуудад чанарын удирдлагын систем, цахим систем, төрийн байгууллагын бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслүүд болон инновац нэвтрүүлэх асуудлыг бодлогоор дэмжих

6.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган, тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

6.2.1. Орон нутгийн хэрэгцээ шаардлага, онцлог, хүний нөөцийн төлөвлөлтөд үндэслэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, чадварлаг, мэргэшсэн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдсэн олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх

6.2.2. Төрийн албан хаагчийн чадамжид тулгуурлан мерит зарчмаар ажлын байранд сэлгэх, шилжүүлэх, дэвшүүлэн төрийн бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

6.2.3. Мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол сайн биелүүлж, ажлын амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ тогтмол дээшлүүлж байгаа төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

6.2.4. Тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээлтэй, 10-аас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдад нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг орон нутгийн төсвөөс олгох

6.2.5. Аймаг, орон нутгийг хөгжүүлэх, салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, бодит үр дүнд хүрсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж өндөр амжилт гаргасан, олон нийтийг эерэг өөрчлөлт, сайн үр дүн гаргасан төрийн албан хаагчдыг урамшуулах

6.2.6. Тогтвор суурьшилтай ажилласан, ажлын амжилт гаргасан төрийн албан хаагчдыг гадаад улсад болон шууд харилцаатай гадаад улсын хотуудад туршлага судлуулах, түүх дурсгалын газруудаар аялуулах зэргээр урамшуулах, дэмжлэг үзүүлэх

6.2.7. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр болон сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ бусдад үнэ төлбөргүй өгч донорын үүрэг гүйцэтгэж буй, өөрөө болон түүний гэр бүлийн гишүүд эс, эд, эрхтэн солиулах, шилжүүлэн суулгах эмчилгээнд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх

6.2.8. Төрийн албанд тогтвор суурьшилтай болон үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг амины орон сууц барих, орон сууц олгох, мөн худалдан авах болон орон сууцны нөхцөл сайжруулахад зохих дэмжлэг үзүүлэх

6.2.9. Төрийн албан хаагчийн өрхийн орлого буурч, нэг гишүүнд ногдох хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшинд хүрэхгүй болсон тохиолдолд гэр бүлийг нь дэмжиж 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн буцалтгүй тусламжийг нэг удаа олгох

6.2.10.Төрийн албан хаагч өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор өрхийн аж ахуй эрхлэхэд нь шаардагдах мэргэжлээр суралцахад нь дэмжлэг үзүүлэх

6.2.11.Шинээр инновац нэвтрүүлж үр дүн гарсан, нэн шаардлагатай мэргэжлээр үр дүнтэй ажиллаж байгаа бол төрийн албан хаагчдад орон сууц олгож болно

6.3.Өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан төрийн албан хаагчийг тасралтгүй сургаж хөгжүүлэх зорилтын хүрээнд:

6.3.1.Мэргэшсэн төрийн албан хаагч бэлтгэх, сургах чиглэлээр Засгийн газрын захиалгат сургалтад холбогдох албан тушаалтнуудыг хамруулан шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх

6.3.2.Төрийн албаны хаагчийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж, шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх

6.3.3.Төрийн албан хаагч өөрийн хүсэлтээр дипломын болон зэрэг, цол авах 90 хүртэл хоногийн хугацааны сургалтад хамрагдахаар бол байгууллагын зүгээс ажлын цагийн болон сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх

6.3.4.Төрийн албан хаагчийн тогтвортой ажилласан хугацаа, ажлын үр дүнг харгалзан гадаад оронд сургалтад хамруулах, дэмжлэг үзүүлэх

6.3.5.Төрийн албан хаагч өөрийн хүсэлт, зардлаар өндөр хөгжилтэй орнуудад магистр, докторын сургалтад хамрагдах тохиолдолд зохих дэмжлэг үзүүлэх

6.3.6.Байгууллага бүр шинээр томилогдож буй албан хаагчдад зориулан ажилд авах үеийн сургалтын гарын авлага боловсруулж, зөвлөх сургалтуудыг ажлын байран дээр зохион байгуулж хэвших

6.3.7.Аймаг, сумдын төрийн албан хаагчдын туршлага, мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэх

6.3.8.Төрийн албан хаагчийн их дээд сургуульд багшлах, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны багт ажиллахад дэмжлэг үзүүлэх

6.3.9.Сургалтын төрөлжсөн байгууллага болон гадаад орнуудын оюуны хөрөнгө оруулалтыг татах орчин нөхцөлийг бүрдүүлэх

6.3.10.Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын сургалт зохион байгуулах иж бүрэн тоноглогдсон сургалтын танхимыг байгуулж, сургалт явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

6.3.11.Төрийн албан хаагчийн туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, инновац нэвтрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаагаар чадавхыг дээшлүүлж албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлснээр төрийн байгууллагын бүтээмжийг сайжруулах

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

7.1.Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллуулах, бүтээмжийг дээшлүүлэхэд идэвх, оролцоо, санаачилга, чадвар, боломжийг нэмэгдүүлэх;

7.2.Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тэгш зарчимд суурилах;

7.3.Төрийн албан хаагчийн сурах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн хүрээнд явуулна;

7.4.Төрийн албан хаагчийн сурах болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон зарим асуудлыг орон нутгийн төсвөөс зохицуулна;

7.5.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь төрийн албан хаагчдад үр нөлөө үзүүлсэн ашиг тустай бодит дэмжлэг болно.

НАЙМ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2023-2026 он хүртэл 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1.Хөтөлбөрийг аймаг, сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн байгууллагууд зохион байгуулах, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь Салбар зөвлөл хамтран гүйцэтгэнэ.

9.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, тайлан, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл болон аймгийн ИТХ-д тус тус тайлагнана.

АРАВ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

10.1.Төрийн байгууллагын төсөв, өөрийн орлого (аймаг, орон нутгийн төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн байгууллагын төсвийн 0.5-1.0 хүртэл хувийг төлөвлөх)

10.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардагдах хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, санхүүжүүлэх

10.3.Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн зардал.

АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ДҮГНЭХ

11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжүүд, Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь салбар зөвлөл нэгтгэлийг хийж хяналт тавина.

11.2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хөтөлбөрийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь гарсан үр дүн, хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийг аймгийн Засаг дарга болон нийт төрийн албан хаагчдад мэдээлнэ.

АРВАН ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

12.1.Төрийн албан хаагчийг сургах болон ажиллах нөхцөлийг сайжруулснаар орон нутгийн бодлого, шийдвэрийн үр дүн, хэрэгжилт сайжирч, төрийн бүтээмжийн чанар, үйлчилгээний хүртээмж дээшилнэ.

12.2.Төрийн болон байгууллагын өөрчлөлт, хөгжлийн стратегитай уялдуулан шинэ мэдээ, мэдээлэл бүхий суралцагч, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлсэн байна.

12.3.Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч, хөгжих таатай орчин бүрдсэн байна.

12.4.Иргэд, олон нийтийн дунд төрийн албан хаагчдын талаарх ойлголт мэдлэг, хандлага сайжирч, үйлчилгээ авагчдын сэтгэл ханамжийн түвшин нэмэгдэнэ.

АРВАН ГУРАВ . ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

- 000 -

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2021 он)	Хүрэх түвшин			
				(2023 он)	(2024 он)	(2025 он)	(2026 он)
1	Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө, суралцагч байгууллага болоход чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан төсөв, хөрөнгө	Мөнгөн дүн	2.4 сая төг (8 багш)	6 сая төг	6 сая төг	10 сая төг	10 сая төг
2	Сургалтад хамрагдсан Төрийн албан хаагчид	Хамрагдалтын хувь (нийт 4241 албан хаагчийн)	2774 буюу нийт албан хаагчдын 65.4%	70%	75%	80%	85%
3	Тогтвор суурьшилтай ажилласан, ажлын амжилт гаргасан төрийн албан хаагчдын урамшуулал, дэмжлэг (тоо болон мөнгөн дүнгээр)	Нэмэгдүүлэх хувь	220.9 сая төг	3% буюу 6.6 сая төг	5% буюу 11 сая төг	5% буюу 11 сая төг	10% буюу 22 сая төг
4	Гадаад улсад (шууд харилцаатай гадаад улсын хотууд болон бусад улсын хотууд) суралцуулах, туршлага судлуулахад дэмжлэг үзүүлэх (тоо болон мөнгөн дүнгээр)	Хамрагдалтын хувь (нийт 4241 албан хаагчийн)	0	0.3% буюу 12 албан хаагч	0.3% буюу 12 албан хаагч	0.3% буюу 12 албан хаагч	0.4% буюу 16 албан хаагч
5	Орон сууцны нөхцөл сайжруулах, худалдан авахад дэмжлэг үзүүлэх (хамрагдсан албан хаагч)	Хамрагдалтын хувь (нийт 4241 албан хаагчийн)	0	0.25% буюу 10 албан хаагч	0.25% буюу 10 албан хаагч	0.25% буюу 10 албан хаагч	0.5 % буюу 20 албан хаагч
6	Орон сууц олгосон байдал (тоогоор)	Хамрагдсан албан хаагчийн тоо	0	5 ба түүнээс дээш	5 ба түүнээс дээш	10 ба түүнээс дээш	10 ба түүнээс дээш